



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

198 . 2 оны .3. дугаар
сарын . 4 . ны өдөр

Дугаар 42

Улаанбаатар
хот

БОХИР ХӨЛДҮҮСИЙН ЦЭГИЙГ
ШИНЭЧЛЭН ТОГТООХ ТУХАЙ

Мааньтын бохир хөлдүүс хаях цэг нь Баянхошууны гэрийн хороололд ойртсонтой холбогдуулж хөдөлмөрчдөөс гаргасан санал хүсэлтийн дагуу Эрүүлийг хамгаалах яам, Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаа, Ариун цэвэр халдвар судлалын станцын холбогдох мэргэжлийн хүмүүс газар дээр нь явж үзвэл гаргасан протоколыг үндэслэн Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ нь:

НСД-ын 1993 оны 1282-р захирамжаар хүлээнзүй.
~~1. Мааньт дахь бохир хөлдүүс хаяж байсан цэгийг 1982 оны 3-р сарын 15-наас эхлэн хааж, цаашид хотын бохир хөлдүүсийг Хамбын овооны ахуйн хог хаягдлын цэгийн арын жалганд хаяж байхаар тогтоосугай.~~

2. Хотын хэмжээний бүх бохир, хөлдүүс, лагийг зөвхөн тогтоосон цэгт хаяж байх, тогтоосон цэгээс өөр газар хаяж байгаа эсэхэд байнгын хяналт тавьж илэрсэн дутагдалд цаг тухайд нь арга хэмжээ авч байхыг Хот тохижуулах газар /н.Бадрах/, АЦХС станц /н.Галсандорж/-д даалгасугай.

3. Хот тохижуулах газар /н.Бадрах/, Октябрийн районы АДХ-ын гүйцэтгэх захиргаа /н.Гунгаажав/-нд даалгах нь:

а/бохир хөлдүүсийн шинэчлэн тогтоосон цэгийн доод хэсэгт жалганы эхнээс 50 метрын зайнд тусгай зургаар даланг /хаалт/ энэ оны 5-р сарын 30-ны дотор байгуулах;

б/бохир хөлдүүсийг долоо хоног бүр даруулж, ариутгал цэвэрлэгээг хийлгэж байх;

в/дээрхи цэгээс 2,0 км-ийн дотор мал бэлчээрлүүлэх, албан байгууллага, айл өрхийг байрлуулахыг хориглох;

2.

г/Мааньтын хөлдүүсийн хуучин цэгийг 5-р сарын I-ний дотор дарж, шаардагдах ариутгал, цэвэрлэгээг хийлгэж дуусгах;

4.Мааньтын цэгийг дарж устгах, ариутгал хийлгэх, шинэчлэн тогтоосон цэгт хаалт, байгуулахад шаардагдах хөрөнгийг 1982 оны хот тохижуулах зардлаас гаргаж санхүүжүүлэхийг Хот тохижуулах газар /н.Бадрах/-т зөвшөөрсүгэй.

5.Бохирын цэгийн орчны бохирдолт, ариун цэврийн шаардлага, ариутгал, устгалтын ажлыг сар бүр шалган үзэж холбогдох арга хэмжээ авч байхыг АЦХ судлалын станц /н.Галсандорж/-д үүрэг болгосугай.

6.Бохир хөлдүүс, лагийг энэхүү цэгээс өөр газар хаяулахгүй байх талаар нутаг дэвсгэрийнхээ албан байгууллага, ОСГ-ны хороодод мэдэгдэж биелэлтийг байнга шалгаж арга хэмжээ авч байхыг районы АДХ-ын гүйцэтгэх захиргааны дарга нарт даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ
ДАРГА *Н.Бадрах* С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА *Ц.Жамбал* Ц.ЖАМБАЛ